

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVIII (610)

DOI: 10.22353/ms20244811

ТҮҮХЭН СУРВАЛЖУУД ДАХЬ НЭГЭН ДОМГИЙН
ХУВИЛБАР, УРАН САЙХНЫ ОНЦЛОГ¹

Г.Нарантунгалаг

Агуулгын товч: Түүхэн үйл явдлыг уран сайхны хэлбэрт оруулах, уран сайхны домгийг түүх бичигч өөрийн санаа бодол, үзэл хандлага, цаг үеийн байдлыг тусган нэмэн дэлгэрүүлэх, хураан товчоолох нь XVII-XVIII зууны түүхэн сурвалж бичгүүдийн бичлэгийн үндсэн арга юм. Бид энэ удаад “Тогоон тайшийн домог” гэж болзмолоор нэрлэсэн домгийн хувилбаруудын харьцаа, тэдгээрийн уран сайхны онцлогийн талаар авч үзэв. Уг домогт тухайн үеийн монголын нийгмийн цаг төрийн байдлыг тусган үндсэн санааг уран сайхнаар гүнзгийрүүлэн дүрсэлсэн бөгөөд ерөөс түүхэн домгийг тухайн улсын улс төр, нийгмийн амьдралд нөлөө үзүүлсэн үйл явдал, тэрхүү үйл явдлын оролцогчтой холбон бүтээдэг түгээмэл зүй тогтолтой байдгийг энэхүү домог мөн харуулж байна.

Түлхүүр үг: XVII-XVIII зууны түүхэн сурвалж, түүхэн домог, домгийн харьцуулал, Тогоон тайш

Удиртгал

XVII-XVIII зууны монгол түүхэн сурвалжаар уламжилж ирсэн домгуудыг харьцуулан судлахын тулд домог, түүхэн домгийг нэр томъёоны болон ойлголтын хувьд ялган ойлгох нь чухал. Ертөнцийн тоо томшгүй юм, үзэгдэл нь анхдагч эх үүсгэвэртэй байх бөгөөд он цагийн уртад агуулга нь баяжиж, хэлбэр нь хувьсан өөрчлөгдөж ирдэг. Тухайлбал, домог, үлгэр нь ертөнцийг таньж мэдэх хүний сэтгэлгээний уламжлалт хэв маяг, бүтээлч хандлагатай холбогдох ба шүтлэг мөргөл, алив нэгэн түүхэн хэрэг явдлаас улбаатай байдаг.

Тиймээс түүхэн домгийн үндэс (үйл явдлын он цаг, зохиогч, газар орон гэх мэт)-ийг тодруулах нь тухайн цаг үеийн хүний сэтгэлгээ, бүтээн туурвих арга барил, улс төр-нийгмийн харилцааны нөхцөл байдал хийгээд хувь хүний хандлага үнэлэмжийг танин мэдэх ач холбогдолтой юм. Судлаачид домгийг *миф* (myth), *легенда* (legend) гэсэн хоёр үндсэн хэсэгт хуваан үзэж байна. *Домог* (грек. mythos) нь түүхэн домгоос ялгаатай бөгөөд ертөнц, юмс үзэгдлийн үүсэл, зөгнөлт төсөөлөл, ертөнцийг үзэх үзлийн шинжтэй “бурхад, баатруудын тухай, ертөнцийн үүслийн тухай, ертөнцөд хүний эзлэх байр суурийн тухай төсөөллийг дамжуулах үг, яриа” (1984;274) юм. Энэхүү “*миф*”-ийг судлаачид *домог үлгэр, домоглол* (1978;303) гэнэ хэмээжээ. С.Дулам “Европ дахины хэлнээ, тэр дундаа англи

¹ МУИС-ийн Р2019-3765 залуу судлаач дотоод төслийн хүрээнд гүйцэтгэв

хэлэнд *myth, mythology* (франц. *mythe, mythologie*, орос. миф, мифология) гэж хэлдэг тэр үзэгдлийг *домог, домог зүй* гэхчлэн томъёолж заншаад байна (2009;1). Монгол хэлний тайлбар толиудад “Домог” хэмээх үгийг хэрхэн тайлсан байна вэ? “Монгол үгсийн язгуурын толь”-д *Domuу-* 1. Балар эртний хүмүүсийн байгаль, нийгмийг ухамсаргүй таньж тайлбарласан хий хүслийн уран бүтээл: Галба дэлхий буй болсон тухай домог; эрхий мэргэний нар харвасан домог; Догшин хар лусыг дарсан домог, 2. <sil> Хүн юмны тухай уламжлагдсан ардын аман зохиолын нэг хэлбэр, домог яриа ч гэнэ, бас уламжлал яриа гэдэг. Эргүнэ Хуны домог, Аргасун хорчийн домог, 3. Инээдэм шог, элэг доог: олны домог болох. Домог доог гарал нэг бололтой. Домог (*domuу*), домоглох (*domuуlaqu*), домоглол (*domuуlal*), домоглиг (*domuуliу*), домогч (*domuуči*), домогтон (*domuуtan*), домогжих (*domuуjigu*) (1988;2122) гэхчлэн тайлсан нь “*domuу*” гэдгийг анхдагч язгуур хэмээн үзсэнийг гэрчилж байна (2009;1) хэмээн домог, домоглол гэж нэрлэн ангилсан байна. Харин үлгэр домог, түүхэн домог нь (лат. *legend*-уншлага, уншигдсан зүйл, өдөр тутмын уншлагын эмхэтгэл) гэгээнтний намтар гэсэн утгаар хэрэглэгдэж байгаад улмаар бодитой үйл явдал, газар нутаг эсвэл тодорхой хүний тухай ер бусын түүх, хууч яриаг нэрлэх (1984;317) бөгөөд “Легенда” гэдэг үгийг судлаачид түүх домог, уран домог, домог, түүхэн домог яриа зэргээр нэрлэж судалжээ.

Тухайлбал, Ц.Дамдинсүрэн “Түүхэн домог” шиг зүйлийг хааяа “хууч хөөрөх” гэдэг боловч аман өгүүллэгт хэтрүүлэн давуулсан зүйл бараг байдаггүй, түүхэн домогт давраулсан уран саналгын нэмэр үлэмжхэн байдаг (1987;132). Ш.Гаадамба “Түүхэнд үнэхээр болсон ортой явдлаас эх сурвалж аваад, түүнээ зохиогч буюу өгүүлэгчийн уран сэтгэмжээр нөхөж чимэглэн, уран зохиолын янзтай болгож туурвисан зүйлийг бид домог гэдэг” (1977;152), Д.Цэрэнсодном “Эртний латин хэлний ариун нандин түүхт явдлыг нэрийдсэн утга бүхий *legende* гэдэг үгийг өрнө дахины олон улс орон домог, домог яриа гэсэн утгаар хэрэглэсээр иржээ. Аль нэгэн цагт болсон буюу болсон байж болох бодит явдлаас сэдэвлэн уран сайхны аргаар хэтрүүлэл, давуулалтай өгүүлсэн богино хэлбэрийн хүүрнэл зохиолыг домог гэдэг байна (2011;411). Оч нар “Түүхэн домог яриа бол түүхт хэрэг явдал түүхт хүнээр үндэслэл болгож, уран сэтгэмжийн аргаар хүүрнэн тоочсон богино үлгэр юм. Түүхэн домог ярианы гол баатар, үндсэн үйл явдал нь хүн, түүхт хэрэг явдал болох ба нийгэм түүхийн янз бүрийн үед нийгэмд хувь нэмэр үзүүлэгсдийн хэрэг учрыг бичиж, өөрийн ойлголт үзэлтээ илтгэдэг байна.

Олонх түүхэн домог яриа түүхээр үндэслэл болгон үлгэрээ зохиомжилдог ч урлагийн хэтрүүллийг хэрэглэдэг болохоор зохиомол хийсвэр зүйл ч өдий төдий байдаг. Алунгоо хатан таван сумаар хүүхдээ сургасан домог, Дува сохорын домог яриа, Бодончар мунхагийн домог яриа, Есүхэй баатрын домог яриа, Чингис хааны тухай домог ярианууд бүх түүхэн хэрэг явдлыг өгүүлэн тоочиж, тухайн үеийн хүмүүсийн танилт үзэлт, нийгмийн ахуй байдал, жич аж амьдрал, зан үйл, шүтлэг бишрэл зэргийг нь нэлээд үнэнчээр тусган үзүүлсэн байдаг (2015;135) гэжээ. Судлаачдын дээрх тодорхойлолтуудыг хураангуйлбал

Ц.Дамдинсүрэн “Монголын уран зохиолын өв уламжлал” номдоо “Түүхэн домог”, Ш.Гаадамба “Монголын уран зохиолын тойм-II” ботид “Уран домог”, Д.Цэрэнсодном “Монгол аман зохиолын тайлбарт дээж бичиг” номдоо “Домог яриа”, Г.Нандинбилиг, С.Дулам нар “Монгол аман зохиол” номдоо “Түүхэн түүх домог”, Оч нар “Монгол аман зохиолын удиртгал” номд “Түүхэн домог яриа” гэж нэрлэж судалсан юм.

Үндсэн хэсэг: XVII-XVIII зууны түүхэн сурвалжуудад уламжлан ирсэн түүхэн домгуудаас бид энэ удаад “Тогоон тайшийн домог” гэж болзмолоор нэрлэсэн домгийн түүхэн үндсийг авч үзнэ. “Тогоон тайшийн домог” нь “Хаадын үндэсний хураангуй алтан товч” 1606-1635, Лувсанданзан “Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан алтан товч хэмээх оршив” 1634, Саган сэцэн “Хаадын үндэсний эрдэнийн товч” 1662, Жамбын “Асрагч нэртийн түүх” 1677, “Эртний монголын хаадын үндэсний их шар тууж оршив” 1695, Ломигийн “Боржигид овгийн түүх” 1732, Мэргэн гэгээн Лувсанданбийжалцан “Их Монгол улсын үндсэн алтан товч оршив” 1765, Рашпунцаг “Болор эрих” 1775 зэрэг сурвалжаар уламжлагдан иржээ. Энэхүү домгийн түүхэн үндэст холбогдох мэдээлэл, түүнийг тайлбарласан түүхийн судалгааны бүтээлээс хайн үзвэл дараах баримт тодорхой болж байна.

Ойрадын Батула чинсан, Элбэг нигүүлсэгч хааны охин Самар гүнжийн хөвүүн Бахаму 1390-ээд онд төрсөн бөгөөд 1415 оны үед зүүн монголын довтолгооноор Арагтай тайшид олзлогджээ. Энэ тухай “Эртний монголын хаадын үндэсний их шар тууж оршив”-д “Адай хаан, Адай тайж, Арагтай тайш гурвуул мордож Зэлмэн, хан хэмээх газар Дөрвөн Ойрадыг довтолж, олз болгон авч ирсэнд “Батула чинсангийн Бахаму- барьж ирсэнд, Ажай тайж: эгч Самар гүнж сайн хийсэн билээ, энэ хөвгүүнийг тавья хэмээсэнд хортын үр билээ гэж Арагтай тайш: Намайг араг үүргэж [Арагтай] нэр өгч билээ гэж Бахамуг тогоон дотор хөмрөн Тогоон нэр өгч зарж явтал Самар гүнж биеэр гуйж аван харив” (2006;47) гэж Тогоон олзлогдсон, нэр нь Бахаму, Тогоон гэдэг нь хоч нэр байсан, эх Самар гүнж гуйж олзноос чөлөөлсөн тухай өгүүлнэ.

Тогооны нэр “Мин улсын магад хууль”-д 1418 оны 3-р сарын хөх нохой өдөр Мин улсын хаанд Тайпин, Батболд болон түүний дүү Энх нарын хамт элч илгээн эцгийнхээ Шүнньин ван цолыг залгамжлуулахыг хүссэнээр илэрдэг. Улмаар 4-р сарын хөх луу өдөр Тогооныг Шүнньин ван өргөмжилжээ. Тайпин болбоос Үгэчи хашихагийн хөвүүн (2018;77). Ойрадад элчээр очсон тайган Хайдун 1417 оны 4-р сарын шарагчин туулай өдөр айлтгахдаа, “Ойрадууд эхэндээ эсэргүүцэж, бүгд Батулаг зөвтгөнө, эдүгээ Батула үхэж, Тайпан, Батболд хоёр хүн нэг сэтгэлээр элч илгээв” хэмээснээс үзвэл энэ үед Тогоон зүүн монголд байсан бололтой. Үүний дараа, 1417 оны намрын сүүл сард Ойрадууд Угж голд Арагтайтай хийсэн дайнд ялсан байдаг. Энэ талаар Н.Сүхбаатар “Цорос овгийн түүх” бүтээлдээ “Зүүн монголд жил гаруй байсны эцэст, эх Самар гүнжийн гуйлтаар 1417 оны сүүлээр Тогооныг Ойрад руу буцаажээ”(2022;68) хэмээн тэмдэглэжээ. “Монгол улсын түүх” бүтээлд “Монгол орны баруун, зүүн хоёр талд хоёр хаан нэгэн зэрэг хаан суух болсон улс төрийн хямралт байдалтай үед Ойрадын Батула чинсаны хүү

Тогоон тайшийн үеэс (1417-1438) Баруун монгол ихэд хүчирхэгжив. Тогоон 1418 оноос Мин улстай арилжаа нэвтрэлцэн Сартуул, Уйгур, Хар Ёгор гурван угсаатан бүхий Юанийн монгол ноёдын хойчис захиран суух халимагийг нэгтгэн, 1420 онд Хамилийн ван Бугадаширт охин Нугандашраа өгч худ ураг барилдав. Мөн тэрээр Шагжау, Хандун, Чигин зэрэг Баруун гурван харуулын монгол ноёдтой холбоо тогтоожээ. Тогоон тайш Чингисийн Алтан ургийн Тогтобухыг 1432\3 онд хаан өргөмжлөн, Зүүн Монголын Аругтай тайш, Хасарын угсааны Адай хааны эсрэг тэмцэн, Дөчин түмэн монгол, Дөрвөн түмэн Ойрадыг нэгтгэхийг зорив. Тогоон тайш 1438 онд Адай хааныг довтлон Монь уул, Цагаан нуурын орчим мөхөөн, хорь гаруй жил үргэлжилсэн хямралыг намжаах үндсийг бүрдүүлэв. 1439 онд олон монгол аймгийн ноёдын хуралдайгаар Тайсун цолт Тогтобух (1432\3-1452) монгол, ойрадын улс төрийн зүтгэлтнүүдийн тусламж дэмжлэгтэй дахин хаан өргөмжлөгдөн, төрийн эрхийг өөрийн гарт бүрэн төвлөрүүлсэн байна” (2019:212) гэсэн нь домгийн түүхэн үндэс, түүнд холбогдох он цагийг тодруулж байна.

Түүхэн сурвалжууд дахь домог, түүний хувилбар. Түүхэн домгийг тухайн улсын улс төр-нийгмийн амьдралд үлэмж нөлөөлсөн үйл явдал, тэрхүү үйл явдлын оролцогчтой холбон бүтээдэг түгээмэл зүй тогтолтой байдаг. Тиймээс түүхэн домог бол түүх уран сайхны нийлэг шинжтэй, сурвалжаас сурвалжид товчоолох, дэлгэрүүлэх, хураах зарчмаар бичигддэг, түүхт явдалд оролцогч болон түүнийг бичигчийн хандлагыг шингээсэн, тухайн ард түмний аман билиг, ертөнцийг үзэх үзлийг тодорхой хэмжээнд агуулсан бүтээл юм. Уг зүй тогтлыг тодруулах үүднээс “Тогоон тайшийн домог”-ийн өгүүлэмж, бүтэц зохиомжоор жишээлэн авч үзье. Цуваа цагийн үүднээс авч үзвэл эрт тэмдэглэгдсэн “Хураангуй алтан товч”, Лу “Алтан товч” сурвалжууд уг домгийг маш дэлгэрэнгүй бичсэн байна.

Түүнийг буулгавал: “Ойрадыг довтолж, Таюугийн хөвгүүн Батула чинсанг алж, эмийг нь хаан биедээ авав. Хөвгүүнийг нь Тогооныг Аругтай тайшийн хонь адуулуулав. Ойрадын нэгэн төрийг монгол авав гэх тэр буй. Адай хаан түүний хойно өвөр зуураа чуулган болов. Тогоон тайш хонь адуулж явтал, чуулганаас харьж ирэх хүн учрав. Тэр чуулганаас харьж ирэх хоёр хүнээс чуулганы хөөр (үг) юун буй гэж Тогоон тайш асуув. Тэр хүн өгүүлрүүн: “Чамайг үгүй гэж эс хэлэлцэв” гэж элэглэв. Тэр хүнийг эчсэн хойно Тогоон малгайгаа авч, таны /та нарын, хөр/ ам бус тэнгэрийн зарлиг буй за гэж тэнгэрт мөргөв. Аругтай тайш эмдээ өгүүлрүүн: “Энэ Тогоон тайш сайн хүний үр байнам. Үүний илт үсээ самлаж /самнаж, хөр/, биеэ маажихыг нуултай гэв. Тэр үгэнд Тогоон гадна гараад таны /та нарын, хөр/ ам бус тэнгэрийн зарлиг буй за гэж тэнгэрт мөргөв. Түүний хойно, Онуй ага, Тогоон тайшийн үсийг нь самлаж суухуйд, Аругдай тайшийн дүү нь өгүүлрүүн: “Энэ Тогоон тайш их хүний үр гэлээ. Үсийг нь самлахуйгаа байж, гол нь самла, эс бөгөөс хөөж орхи” гэж хэлэв. Энэ үгэнд Онуй ага хориглож, эс болов. Дүү нь бас өгүүлрүүн: “Энэ үгэнд хориглох болбоос тэргүүгээ /толгойгоо, хөр./ бүү гэмчлэгтүн” /толгойгоо бүү шаагтун! хөр./ гэв. Тэр үгэнд, монголын хүүхэн /хүүхэд, хөр/ ээрч уйлам. Адуугаа хашхирч хураам,

нохой нь ульж хуцам, ийм муу ёрыг нь Тогоон тайш мэдэж тэнгэрт мөргөв. Түүний хойно, Тогооны эх, Адай хаанд өчрүүн: “Намайг асарч хатан болгов чи. Хөвгүүнийг минь Тогооныг хүнд яахин заруулнам, чи. Алж орхи. Үгүй бөгөөс үлдэж орхиосой гэв. Хатны тэр үгийг хаан зөвшөөж, Тогоон тайшийг Силамучин, Саймучин нэрт хоёр элчээр газарт нь хүргүүлэв. Тогоон тайшийг хүрсний хойно, Ойрад, Өөлд, Баатад, Хойг /хойд, хөр/ эд дөрвөн түмэн чуулган болж, Тогоон тайшаас үг асууруун: “Монголын хаан тайш эхлэн их улсын зан ааль ямар буй” гэж асуув. Тогоон тайш хэлрүүн:

*“Монголын Аругдай тайш өтөлж
Аливаа үйл усгал мэт санагдам.
Саадаг нь хувилж
Санаа нь эс хувилж
Төр мэдэхүй сайдаа гадна суулгам
Зэвийн морио /байлдааны морио, хөр./ гэр дээр /гэр зуур, хөр/ унам.
Өчүүхэн мэдэх хүнийг төрд явуулнам
Үрээ морийг зэвлэм,
Босгуул хүнийг төр мэдүүлэм
Борви хөхүүрт сархад хийм,
Буур үгүй тэмээ,
Бух үгүй үхэр,
Азрага үгүй адуу,
Хуц үгүй хонь мэт.*

Энэ үгийг үл итгэх болбоос, Үгэчи хасаха болготугай гэв. Монголын элч Силамачин, Саймучин хоёр аргаар хуурч, сайн морь, булга, шилүүс, сайн эд таваарыг Тогоон тайш, Адай хаанд хүргэж улсаас зах гэж нүүдэлд хүрч ирвэй. Хаан үзэж зарлиг болруун: “Тогоон тайшийг газарт нь хариулсан ач нь энэ буюу. Силамачин, Саймучин хоёр ойрад сэжиггүй байнам. Холоос Тогоон тайш чилж албыг чинь хүргэв. Гагц өдөр өнжөөсэй” гэж айлтгавай. Хаан зөвшөөж, харь хүнийг хүндэлье гэж өнжив. Тогоон тайшийн хойноос дөрвөн түмэн Ойрад цэрэг ирж Монголыг довтолж, Адай хааныг Тогоон тайш мөн дээр барив. Тэндээс хаан зарлиг болруун: “Эхийг чинь хатан болголоо. Биеийг чинь эс аллаа” гэв. Тогоон тайш өгүүлрүүн: “Эх минь эр үгүй билүү. Бие минь эцэг үгүй билүү” гэж хааныг хороохуйд хаан зарлиг болруун: “Силамачин, Саймучин хоёрын үгэнд итгэж нэгэн сум эс хариулж үхвэй зэ” гэв. Адай хаан их ор сууж, арван дөрвөн он болсны хойно морин жилд ойрадын Тогоон тайшийн гарт тэнгэр болов. Монголын нэгэн төр ойрадад автсан нь тэр гэх (2015;256)

Саган сэцэний “Хаадын үндэсний эрдэнийн товч”-д уг домгийн дээрх хоёр сурвалжид тэмдэглэгдээгүй өгүүлэмж болох “Тогоон тайш хааны цамхагийг гурвантаа эргэж дайрлан цавчиж, чи суутын цагаан гэр бол, би сутайн үр Тогоон байна хэмээн өгүүлэхэд, Ойрад, Монголын иргэд “чиний үг авир чинь асар муу” эзэн богдод ачлан мөргөж, амиа гуй гэхэд би өөрийн амиа өөр хэнээс гуйх вэ? Одоо хамаг монгол минийх болов. Би урьдах монголын хаадын ёсоор хан цолыг авсугай” хэмээгээд, эзэнд тавиг тавиад, эргэхэд нь эзний алтан хоромсого тас

хэмээн дуун гарахуйд дэргэд нь харж үзвээс, дундад нүдэн дэх нэгэн хийврийн төмөр онь хоёрт нь цусан бүхийг үзэж, Дөчин Дөрвөн бүхнээр эзэн эс таалбай хэмээлджээ. Төдий хөвгүүнээ Эсэнийг дуудаж ирүүлээд,

Эр Суут эр юүгээн өдүүлбэй

Эм Сутай өвөрдөн эс чадвай

Эх Сутайд эрэн явсаар

Эзэн богдод ийн хийгдвэй би

Үүргэснийг чинь арилган баржам

Үлдсэн нь гагцхүү Монголжины Мөнхбай буюу хэмээгээд амин гарсан гэжээ. Судлаачид уг сурвалжийн онцлогийн талаар “Хураангуй алтан товч”, Лувсанданзаны “Алтан товч”, “Шар тууж”, “Алтан хааны тууж” болон Хятад сурвалж бичгүүдэд байдаггүй олон чухал мэдээг тэмдэглэн үлдээсэн байдгийг дурдсаны дээр сурвалжийн хэлний онцлогийн талаар “XVII, XVIII зууны үеийн зарим сурвалж дахь өмнөх үеийн зохиолоос ашигласан хэсэг болон зохиогчийн боловсруулан нэмж бичсэн хэсэг хэлний онцлог болон найруулгын талаар илэрхий ялгаатай” байдгийг тодруулан тэмдэглэсэн байна. Саган сэцэн зохиолоо бичихэд долоон зүйлийн судрыг нийлүүлэн үзсэнээ төгсгөлийн шүлэгтээ нэр зааж дурдсан бөгөөд тэдгээр нь,

Түүнчлэн үзсээр “Утгат чухал хэрэглэгч” хэмээх судар

Тийн “Гайхамшигаа үзэгдэхүй цэцгийн цоморлиг” нэрт шастир

Тэгшид “Чанар шалтгаан үндсийг ухуулагч Улаан дэвтэр”

Тэр мэт Сарба хутагтын зохиосон “Хаадын үндэсний тууж”

“Эрдэмтний сэтгэлийг гийгүүлэхүй цэцэрлэг” хэмээх хятадын шастир

Эрхэм дээд Чакраварди хааны байлгасан “Номын цагаан түүх”

“Эртний Монголын хаадын үндэсний их Шар тууж” эдгээр зохиол болно.

1677 оны зохисон гэж үздэг Жамбын “Асрагч нэртийн түүх”-д домгийн үндсэн санааг хадгалж, уран сайхны хувьд хураангуй “Алтан товч”, Лу “Алтан товч”-д байх домгийн өгүүлэмжтэй ижил боловч шүлгийн уран сайхны хувьд бага зэргийн зөрөө байгаа нь “Өчүүхэн хүнээр төр мэдүүлнэм, үрээ мориор зэвлэм” гэх хоёр мөрийн хооронд “хуягийн морио айл зуур унанам” гэж, “Босгуул хүнээр төр мэдүүлэм” гэх мөрийн араас “Борвит архиар жаргал хийнэм” гэж тухайн үеийн монголын нийгмийн цаг төрийн байдлын ороо бусгаа байдлыг тодруулж, үндсэн санааг гүнзгийрүүлж тусгажээ.

“Эртний монголын хаадын үндэсний их шар тууж оршив” сурвалжид өмнөх хувилбарууд дахь Тогоон зүүн монголд байсан, Аругтайд зарцлагдсан, Адай хааныг хороосон, хааны ордонг дайрсан гэсэн өгүүлэмжүүд бүгд бий хэдий ч уран сайхны хувьд дүрслэл бага товчоолох хэлбэрээр бичсэн байна.

Энэ домгийг нэлээд хураасан хувилбар нь “Боржигид овгийн түүх”, Мэргэн гэгээн Лувсандамбийжалцан “Их монгол улсын үндсэн алтан товч оршив” сурвалжуудад байна. Тодруулбал, “Боржигид овгийн түүх”-д “Ойрад улс самуун болжээ. Энэ тухай тэнгэрт залбирч мөргөөд, цэрэг авч ирвээс зохимуй хэмээн сургаж илгээв. Гурвуул Монгол улсад хүрч ирээд, Адай хаанд хэлсэн хойно, хаан

зөвшөөж, Арагтайг тайш өргөмжлөөд, хааны бие, Адай тайж, Арагтай тайшийн хамт цэрэглэн, Ойрад улсыг дайлж их л эвдлээд, Батула Чинсангийн хөвгүүн Багму-г барьж авчрав. Арагтай тайш Багму-г боол болгож гэртээ зарцлан, үүний эцэг Батула угаас түүнийг араг үүрүүлээд, аргал чөмбүүлж, Арагтай хэмээн нэрлэсэн тул, Багму-г тогооны дотор илгээж унтуулаад, Тогоон хэмээн нэрлэв. Хойно Самур гүнж Ойрад газраас ирсэн Тогооныг өөрийн хөвгүүн хэмээн гуйж, уг газарт аваачив.

Тогоон Ойрад улсад хүрээд, өөрийн доорд Дадайн зүг өгүүлрүүн, эдүгээ Монгол улс самуун болжээ, бид цэрэглэж хариу авбаас зохимуй хэмээн хэлэлцэхүйд, эх Самур өгүүлрүүн, хүүхэд хүн биеийг хашруулан зарсан учирт, дэмий хэлэлцмүй. Дэмий л урьдын өшөөг авч юу хиймүй хэмээн ятгаваас үг авсангүй. Дөрвөн түмэн Ойрадыг аваад хааныг хөнөөв” гэж, Мэргэн гэгээн Лувсандамбийжалцан “Их монгол улсын үндсэн алтан товч оршив”-д “Тэндээс Улхуй мэргэн Батулын хөвгүүн Тогооныг барин ирсэнд, эх нь Самар гүнж ирэлцэв. Адай хаан гүнжийн сэтгэлийг харж, Тогооныг эс алав. Цагаан нохой жилд Адай тайж өнгөрөөд, гурван хөвгүүнийг нь Адай хаан үрчлэн асрав. Мөн энэ нохой жил Улхуй мэргэн үр олоогүй өнгөрөөд, оронд нь Шүүсдэйн ахмад хөвгүүн Ноёнболдыг гурван настай зохиов. Тогооныг Самар гүнж авч харив. Адай хаан улаан бичин жилээс эхэлж, хаан болон хорин гурван оны шар морин жил хүртэл Ойрад бүгдийг өршөөн атал Тайсун Агбаржинтан сууриныг яарч хурааж, Саймуужиныг тухираад Адай хааныг хороож, Тайсун хаан болон, Агбаржин жонон болон, Тогоон тайш болов. Мөн даруй Тогоон үхэж, Эсэн тайш болов” зэргээр домгийг хураангуйлан бичсэн байна.

Домгийг хураан бичсэн Ломигийн “Боржигид овгийн түүх”-ийг судлаачид “уг зохиолд агуулагдаж буй зарим түүхэн мэдээ сэлтүүд нь Ордосын Саган сэцэний “Эрдэнийн товч”, Лувсанданзаны “Алтан товч”, “Шар тууж”, “Алтан хүрдэн мянган хэгээст бичиг” зэрэг Монголын түүхийн бусад түүхэн сурвалжуудад адил давхцаж байгааг харьцуулан судалжээ.

Домгийн уран сайхны хувьд түүхэн үйл явдлыг уран сайхны хэлбэрт оруулах, уран сайхны домгийг нэмэн дэлгэрүүлэх, хураан товчоолох нь XVII-XVIII зууны түүхэн сурвалж бичгүүдийн бичлэгийн үндсэн арга, тухайн цаг үеийн бичээчдийн бичих ур чадвартай шууд холбоотой асуудал юм. Зарим судлаач энэхүү бичлэгийн хэлбэр, аргыг *эрхилж товчоолох* хэмээн тодорхойлсон нь уг ойлголтын мөн чанарыг таньж мэдэх, тайлан тайлбарлах нэгэн гол чиглэл болж иржээ. Түүхэн үйл явдал, түүнээс үндэс улбаатай уран сайхны домгийн харьцааг ажиглахад болж өнгөрсөн түүхийн зангилаа асуудал, үйл явдлыг сурвалж бичигт уран сайханжуулан өгүүлэх, уг эхний хувилбараас дараа дараагийн сурвалж бичигт нэмэн дэлгэрүүлэх, хураан товчлох байдлаар дамжуулан бичдэг зүй тогтол бий. Иймд түүхэн домог, түүний хувилбар нь сурвалж бичгүүдийн бүрэлдүүлбэрийн гол цөм бөгөөд тухайн домгийн зохиомж, бүтцийн өвөрмөц шинжийг бүрдүүлдэг байна.

Товчоолох аргын тухай Ч.Билигсайхан, “хамгийн товчоор энэ арга нь түүхэн үнэнийг уран сайхны арга хэрэгслийн тусламжтайгаар бодитой дүр

дүрслэл болгон хувиргаж итгэмжтэй урнаар үзүүлдэг арга” (2000;169) гэсэн бол Г.Билгүүдэй “МНТ-ны 1-р зүйлд тэнгис гэтэлж ирсэн гэсэн өгүүлбэр байна. Энэ бол мөн л Бөртэ чоно, Ухаа марал хоёрын тухай домгийн нэгэн өгүүлэмжийн товчоолол гэж болно. Хэрэв энэ домгийг арай дэлгэрэнгүйгээр тэмдэглэн үлдээсэн бол бид Тэнгис гэдэг үгийн цаана чухам юуг заасныг мэдэх байсан биз ээ. Энэ домгийн өгүүлэмжийг ганцхан өгүүлбэрээр товчлон бичсэн учир үүний тэнгис гэдэг нь далай, нуур, гол гэх мэт олон таамаглалыг гаргахад хүрсэн байна”(2020;64) хэмээгээд эрдэмтдийн болон өөрийн саналыг дэвшүүлэн тайлбарласан бөгөөд эцэст нь “энэ бүхэн юуг харуулж байна вэ гэвэл МНТ-г зохиогч амаар уламжилсан болгоныг эмхэтгээд байсангүй зарим хүний түүхийг товчоолон орхиж байсныг харуулж байна” (2020;64) гэж дүгнэжээ.

Түүхэн домгийг товчоолох, дэлгэрүүлэх, хураах энэхүү арга нь Монголын XVII-XVIII зууны бусад түүхэн сурвалж дахь домогт нийтлэг ажиглагдаж байна. Тухайлбал, “Асрагч нэртийн түүх”-д буй “Тогоон тайшийн домог”-ийн хувилбар нь Лувсанданзаны “Алтан товч”-д буй хувилбартай нэлээд төстэй байна. Харин Рашпунцагийн “Болор эрих”-д буй хувилбарт дурдсан хоёр эхтэй агуулга төстэй боловч *боол хятадаар засгийг бариулан, хуубийн сайдаа хөөмүй* гэх зэрэг тухайн цаг үеийнхээ нийгмийн байдал, нэр томьёог тусган шинэчилж, өөрчлөн найруулсан байна. Дээрх гурван хувилбарыг зэрэгцүүлэн үзүүлбэл,

Лувсанданзан “Алтан товч”	Жамба “Асрагч нэртийн түүх”	Рашпунцаг “Болор эрих”
Тогоон тайш хэлрүүн: Монголын Аругдай тайш өтөлж Аливаа үйл усгал мэт санагдам. Саадаг нь хувилж Санаа нь эс хувилж Төр мэдэхүй сайдаа гадна суулгам Зэвийн морио гэр дээр унам. Өчүүхэн мэдэх хүнийг төрд явуулнам Үрээ морийг зэвлэм, Босгуул хүнийг төр мэдүүлэм Борви хөхүүрт сархад хийм, Буур үгүй тэмээ, Бух үгүй үхэр, Азарга үгүй адуу, Хуц үгүй хонь мэт. Энэ үгийг үл итгэх болбоос, Үгэчи хасаха болготугай гэв.	Тогоон өгүүллүүн, Төр мэдэх сайд гадаа суунам Өчүүхэн хүнээр төр мэдүүлнэм Хуягийн морио айл зуур унанам Үрээ мориор зэр зэвлэнэм Босуул хүмүүнээр төр мэдүүлнэм Борвит архиар жаргал хийнэм Аругтай тайш өтөлж Буургүй тэмээ Бухгүй үхэр мэт байнам. Намайг үл итгэх бөгөөс Үгэчи Хашха-г ац одож мэдэж ирсү гэв.	Тогоон өгүүллүүн: Аругтай тайш өтөлж Аливаа үйл нь осол болжээ Суудал нь хувилан Санаа нь төөрчээ Төр мэдэгч сайдаа үл хэрэглэн Түрэмгий ардын үгийг авмуй Өчүүхэн муу хүнээр төрийг мэдүүлэн Үрээ мориор хуягламуй Боол хятадаар засгийг бариулан Борви хөхүүрт сархад хиймүй Хуягийн морио гэр дээрээ унаж Хуубийн сайдаа хөөмүй Ер эзэнгүй улс мэт Эх үгүй мал мэт байнам хэмээсэн хойно, тэдгээр дөрвөн аймаг бээр цэрэг морио засан бэлдвэй.

Аливаа бүтээл нь хайр сэтгэл, хагацал өнчрөл, өс хонзон, үзэн ядалт, өршөөл уучлал, зөрчил тэмцэл зэрэг сэдэв тухайлсан загвар, уран сайхны хэлбэртэй байдаг. Дэлгэрүүлбэл, монголчуудын уламжлалт сэтгэлгээнд төр бол тодорхой хэм хэмжээ, үнэт зүйлтэй ойлголт байдаг ба тэрхүү тогтсон дэг ёсыг зөрчих нь төр улстай тэрсэлдсэн, нийтийн эрх ашгийг умартсан үйлдэл болдог байна. “Тогоон тайшийн домог”-т гарч буй:

*Төр мэдэхүй сайдаа гадна суулгам
Зэвийн морио гэр дээр унам,
Өчүүхэн мэдэх хүнийг төрд явуулнам
Үрээ морийг зэвлэм,
Босгуул хүнийг төр мэдүүлэм*

Борви хөхүүрт сархад хийм гэсэн хэсэгт нийгэм цаг үнэт зүйлээ гээж, юмсын зохист хэмжээ, байр алдагдсаныг уран сайхны ёгт хэлбэр, төрийн тулгуур-сайдыг өчүүхэн, босгуул хүнээр сольж, цэргийн түшиг-хүлэг морийг үрээ мориор сэлгэсэн байдлаар төлөөлүүлэн уул санаагаа холбосон байна. Ерөөс монгол хүний хувьд хүн, хүлэг хоёр нь юм үзэгдэл түүний гол шинж харьцааг тайлбарлах нэгэн гол дүр болж ирсэн уламжлалтай юм. Жишээ нь: монгол зүйр үгнээ *хүний сайныг ханилан байж мэднэ, хүлгийн сайныг унан байж мэднэ* гэх бөгөөд хүлгээсээ салсан хүн хөлгүйтэй адил, эзнээсээ хагацсан хүлэг ижилгүйтэй адил гэж сэтгэнэ.

*Бух үгүй үхэр,
Буур үгүй тэмээ,
Азарга үгүй адуу,*

Хуц үгүй хонь мэт гэсэн хэсэгт улс үндэстэн хамаарч харьяалах эзэнгүй болж, улмаар мөхөл сүйрлийн ирмэгт ирж буйг эцэг малгүй сүрэгтэй ижилсүүлэн дүрсэлжээ. Монгол хүний хувьд таван хошуу малаар аливаа зүйлийг адилтгах зүйрлэх хэлбэрээр сэтгэдэг нь уламжлалт нүүдэлчин ахуй соёл, ертөнцийг таньж мэдэх, хэмжиж ухаарах аргатай нь холбоотой юм.

Дүгнэлт

“Тогоон тайшийн домог”-ийн хувилбар эхүүдийг харьцуулан үзвэл Хураангуй “Алтан товч”-оор төлөөлүүлсэн дэлгэрэнгүй хувилбар, Ломигийн “Боржигид овгийн түүх”-ээр төлөөлүүлсэн хураангуй хувилбар эхүүд гэсэн хоёр хэсэгт ангилан судлахаар байна.

Монгол орны баруун, зүүн талд хоёр хаан нэгэн зэрэг хаан суух болсон түүхийн эгзэгтэй үед Ойрадын Батула Чинсаны хүү Тогоон хөрш зэргэлдээ улстай улс төрийн харилцаа холбоог гүнзгийрүүлэн хүчирхэгжиж Дөчин түмэн монгол, Дөрвөн Ойрадыг нэгтгэхийг зорьжээ. Түүхэн сурвалжуудад тэмдэглэхдээ энэхүү үйл явдлыг уран сайхнаар баяжуулан нийгэм түүх, цаг үе, газар орон болоод туурвигчийн ертөнцийг үзэх үзэл зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан домгийн хувилбар эхийн бичлэгийн онцлог, ялгаа илэрч байна.

Түүхэн домгийг уран сайханжуулахад товчоолох, дэлгэрүүлэх, хураах арга буйг XVII-XVIII зууны үеийн түүхэн сурвалж дахь “Тогоон тайшийн домог”-оор жишээлэн тайлбарлав. Энд онцлон дурдах нэгэн зүйл бол түүхэн сурвалж нь он цагийн дарааллаар нэгээс нөгөөд хуулбарласан гэхээс илүү хувь бичээч буюу түүх зохиогчийн бичгийн ур чадвар, сэтгэлгээ, үзэл хандлагын үүднээс бичигдсэн, цаг үеийнхээ түүхэн онцлог, үг хэллэгийг тусгасан өвөрмөц шинжтэй байна.

Үйл явдлыг түүх болгон бичих, мөн уран сайханжуулж домог болгоход өгүүлэгч үзэл бодол, хувийн байр сууриа гүнзгий тусгах, дүрслэгдэхүүнийг үндэсний сэтгэлгээний онцлогт тулгуурлан шүлэглэх, үндсэн санааг адилтгалаар урлах зэрэг уран зохиолын төрөл зүйлийн холимог бичлэгийн онцлогтой ажээ.

Ном зүй

- Билигсайхан Ч. (2000) *Монгол эрх товчис*, (түүхэн уран зохиол бүтээх монгол арга бүрэлдсэн нь). Улаанбаатар
- Билгүүдэй Г. (2020) *Монголчуудын аман уламжлал ба “Монголын нууц товчоо”*, Улаанбаатар
- Буяндэлгэр. (2018) *XV зууны эхэн хагасын умард Юань улсын хаадын угсаа залгамжлал ба төрийн байдал*, Орчуулсан Б.Мягмаржав. Acta historica. Tom XIX, fasc 6. Улаанбаатар
- Гаадамба Ш. Цэрэнсодном Д. (1978) *Монгол ардын аман зохиолын дээж бичиг*, Улаанбаатар
- Дулам С. (2009) *Монгол домог зүйн дүр*, Улаанбаатар
- Жамба (2015) *Асрагч нэртнийн түүх*, Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар хийсэн Д.Заяабаатар. Улаанбаатар
- Лувсанданзан (2015) *Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан алтан товч хэмээх оршив*, Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар хийсэн Ш.Чоймаа. Улаанбаатар
- Ломи (2015) *Боржигид овгийн түүх*, Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар хийсэн М.Баярсайхан. Уб. Улаанбаатар
- Монгол улсын түүх*. (2019) Ерөнхий суурь боловсрол эзэмшихэд зориулсан их сургуулийн сурах бичиг. Ерөнхий редактор П.Дэлгэржаргал, Б.Чинзориг, Ж.Болдбаатар. Улаанбаатар
- Дамдинсүрэн Ц, нар (1977) *Монголын уран зохиолын тойм-II боть*. Улаанбаатар
- Лувсанданбийжалцан (2015) *Их Монгол улсын үндсэн алтан товч оршив*, Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар, хавсралт хийсэн Д.Бүрнээ. Улаанбаатар
- Оч нар (2015) *Монгол аман зохиолын удиртгал*, Монгол бичгээс хөрвүүлсэн Б.Мөнхбаяр. Улаанбаатар
- Рашпунцаг (2015) *Болор эрх*. Харгуулан хөрвүүлсэн М.Баярсайхан, Г.Одбаяр, Ч.Нэргүй, Д.Бүдсүрэн. Улаанбаатар
- Саган эцэн (2015) *Хаадын үндэсний эрдэнийн товч*, Сонгомол эх бэлтгэж, хөрвүүлэг, тайлбар хийсэн М.Баярсайхан. Улаанбаатар
- Хаадын үндэсний хураангуй алтан товч (2015), Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар хийсэн Ш.Чоймаа. Улаанбаатар
- Цорос овгийн түүх (2022) *Bibliotheca oiratica* CVIII. Улаанбаатар
- Эртний монголын хаадын үндэсний их шар тууж оршив (2015) Монгол бичгийн эхээс харгуулан хөрвүүлж, тайлбар, хавсралт хийсэн Ц.Шагдарсүрэн, Э.Мөнх-Учрал. Улаанбаатар

Abstract

The basal approach to writing historical sources in the 17th - 18th centuries involved converting historical events into artistic forms while expanding and condensing these events through the lens of the historian's personal thoughts, opinions, and socio-political situation in which they lived. This article examines and interprets the relationship between the various versions of the legend, contingently referred to as the “Legend of Togoon Taish,” and their artistic characteristics. The legend serves as a reflection of Mongolian's social and political conditions in during that time, conveying central themes in a profound and artistic manner. It also depicts a recurring pattern of connecting events that shaped the nation's political and social landscape, alongside the individuals who played key roles in those events, affirming the common characteristics of legends.

Key words: Historical sources of the 17th - 18th centuries, legends, comparative analysis of legends, Togoon Taish